



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠦ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/550

Алтай хот

**Гэрээ байгуулах эрх олгох, хөрөнгө  
гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5, 4.1 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2021 оны 41 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг “Дөрвөн түшээ” ХХК-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т олгосугай

2.Холбогдох хууль, журам стандартад нийцсэн ажлын даалгавар бэлтгэн, гүйцэтгэгч байгууллагад хүргүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нийлүүлэх хугацаа, тоо хэмжээг гэрээнд тодорхой тусган хэрэгжүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т үүрэг болгосугай.

3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хөлс, хэвлэлийн зардал 15,000,000 (арван таван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

4.Ажлын гүйцэтгэл, чанарт хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

